

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар
Сүлжээ төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Өгөгдлийн сүлжээ төлөвлөлтийн
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Компанийн улс болон орон нутгийн өгөгдлийн сүлжээ, интернэтийн бөөний урсгал болон VPN сүлжээний тоног төхөөрөмж, технологийн чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг зохион байгуулж, техникийн нэгдсэн төлөвлөлт судалгаа хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх

Албан тушаалын зорилт:

- Одоо ашиглагдаж байгаа өгөгдлийн сүлжээ болон интернэт сүлжээ, олон улсын гарцын ашиглалтын судалгааг хийж, мэдээллийн санд бүртгэх, өргөтгөл шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх явцад оролцох,
- Өгөгдлийн сүлжээний өргөтгөл, шинэчлэл, техник, технологийн чиглэлээр судалгааг боловсруулах, цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөд уялдуулах, төсөл боловсруулах, төслийн гүйцэтгэлд хамтран ажиллах, угсралт суурилуулалт хийх, ашиглалтанд хүлээлгэн өгөх,
- Өгөгдлийн сүлжээний чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэдээлэл холбооны сүлжээ болон бусад сүлжээний нэгдсэн төлөвлөлт гаргах;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, техник технологитой холбоотой асуудлаар саналаа тусгуулах, техникийн даалгаврыг боловсруулах.

Зорилт

Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг

1 дүгээр
зорилтын
хүрээнд

- Ашиглалтын болон чанарын холбогдолтой өгөгдлийн сүлжээний холболт, дамжилт, сувгийн зохион байгуулалт хуваарилалт, тоног төхөөрөмжийн багтаамж болон хаягийн багтаамж, байршлын судалгаа зэрэг мэдээллийн санг бүрдүүлэн тухай бүр баяжуулах.
- Шаардлагатай технологийн стандарт, дүрэм, журмын мөрдөлтөд хяналт тавих, тэдгээрийг боловсронгуй болгож, сайжруулах;

	<ol style="list-style-type: none"> 3. Тоног төхөөрөмжүүд, сэлбэг хэрэгслийн халуун нөөцийн судалгааг хийж, төлөвлөн боловсруулах, 4. Удирдлагыг мэдээлэлээр хангах, ажлаа тайлагнах, танилцуулах, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлэх,
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Өгөгдлийн болон интернэт сүлжээний шинэ техник технологиудын шаардлага, техникийн тодорхойлолт, хэрэглээ болон үнийн судалгааг хийж, богино, дунд болон урт хугацааны техник, технологи, тоног төхөөрөмжүүдийн төлөвлөлтийн бодлого боловсруулах, 2. Шинээр нэвтэрч байгаа тоног төхөөрөмжийн дагуу техникийн даалгавар болон нөхцөл гаргах чадвартай байх, 3. Хөрөнгө оруулалтын өгөгдлийн сүлжээний тоног төхөөрөмж, техник технологиудын судалгааг хийж, төлөвлөн, боловсруулж, батлуулах, угсалт суурилуулалт хийх, ашиглалтад хүлээлгэн өгөх, 4. Ажлын чиг үүргийн дагуу компаниас хэрэгжүүлж байгаа аливаа төсөл хөтөлбөрт оролцон ажиллах хэрэгжүүлэх, 5. Төсөл хэрэгжүүлэх болон хүлээлгэн өгснөөс хойших техникийн зүгшрэлт, ашиглалт үйлчилгээн дээр хяналт тавих, оролцох ашиглалтын газартай хамтран ажиллах.
3 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Харилцагч компанийн өгөгдлийн сүлжээний дата урсгалын техникийн нөхцөл боловсруулах, 2. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй болон галын аюулгүй ажиллагааг технологийн дагуу хангаж холбогдох дүрэм зааврыг мөрдөж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах, 3. Компанийн дотоод журам хөдөлмөрийн сахилга бат, улсын хяналтын дүрэм, харилцаа холбооны хууль, түүнд заагдсан технологийн дүрмийг баримталж ажиллах, 4. Компанийн эд хөрөнгө санхүүгийн болон нэр хүндэд ноцтой хохирол учруулахгүй ажиллах, техник технологи сүлжээний өгөгдөл мэдээ мэдээллийн нууцлалтыг хадгалах.
4 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Компанийн богино, дунд болон урт хугацааны техник технологийн төлөвлөлт боловсруулах, батлуулах, 2. Гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалт нийлүүлэлтийн ажлын техникийн даалгавар, ажлын зургын дагуу гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавих шаардлага хангасан байдалд үнэлгээ өгөх, 3. Шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтэнгүүдэд орлож ажиллах 4. Олон улсын болон дотоодын үзэсгэлэн, байгуулага, компаниудын сургалт, семинарт оролцож туршлага судлах, суралцах, 5. Тоног төхөөрөмж, үйлдвэрлэгч, нийлүүлэгч гадаад дотоодын компаниуд, тэдгээрийн суурин төлөөлөгчийн газруудтай харилцаа, холбоотой ажиллах, 6. Ажлын чиг үүргийн дагуу шаардлагатай бол гадаад, дотоод томилолтоор ажиллах.

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/;
Мэргэшил	Мэргэшил шаардахгүй. Мэргэшсэн бол давуу тал болно.

Туршлага	Мэргэжлээрээ 5-с дээш, Харилцаа холбооны салбарт 5-аас дээш жил, жил эрхэлсэн байх.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах, багаар ажиллах, асуудалд дүн шинжилгээ хийх, бүтээлч санаачилгатай, баримт, бичиг боловсруулах, гадаад хэлний зохих мэдлэгтэй, хэрэглээний программ дээр ажиллах чадвартай байх.
Ажлын байрны болон орон нутгийн онцлог, цаг үеийн нөхцөл байдал, хүний нөөцийн хэрэгцээг үндэслэн энэхүү тусгай шаардлагын "Туршлага" хэсэгт заасныг тухайн тохиолдолд өөрчлөн тогтоож болно.	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Гүйцэтгэх захирал	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Газрын захирал, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн Нийт: 3	Бусад харилцах субъект: 1. Компанийн нийт ажилтнууд 2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

БОЛОВСРУУЛСАН:	БАТАЛСАН:
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ	ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
 А.ГАНБУЛГА	 Д.МЯНГАНБААТАР
2023 оны 03-р сарын 17-ны өдөр	2023 оны 03-р сарын 17-ны өдөр